

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2021 оны..сарын.. – ны өдрийн тогтоолын ... дүгээр хавсралт*

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
2020-2024 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

**ХАЖУУ ШИНЭ УС  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Сум,дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа аймаг,нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал нэгжийн саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.” гэсэн заалтыг үндэслэн сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсрууллаа.Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилагаас гадна хувийн хэвшил, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн саналд үндэслэн боловсрууллаа.

Уг бодлогын баримт бичигт иргэдийн саналыг тусгахдаа сумын Засаг даргын Тамгын газрын цахим хуудасаар саналыг авсан болно. Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй саналын 80 гаруй хувь нь холбогдож байгаа тул сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаад байна.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 5 бүлэг 5 зорилго 32 зорилт 143 арга хэмжээг төлөвлөн гаргалаа.

Бүлэг	Зорилгын тоо	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1. Хүний хөгжлийн бодлого	1	14	65
2. Эдийн засгийн бодлого	1	7	29
3. Засаглалын бодлого	1	6	23
4. Ногоон хөгжлийн бодлого	1	3	10
5. Орон нутгийн хөгжлийн бодлого	1	2	12
<b>Нийт</b>	<b>5</b>	<b>32</b>	<b>143</b>

Хөтөлбөрийн зорилго, зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн суурь түвшин зорилтот түвшинг тодорхойлохдоо 2016 -2020 оны суурь судалгаанд үндэслэсэн бөгөөд судалгааг сумын ЗДТГазрын албан хаагчдын тухайн салбарын суурь судалгаа, харьяа байгууллагын албан хаагчдын мэдээллийн санд тулгуурлан төлөвлөлөө.

## **АГУУЛГА**

### **НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

1.1 Эрүүл мэнд

1.2 Биеийн тамир, спорт

- 1.3 Боловсрол
- 1.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
- 1.5 Гэр бүл
- 1.6 Үндэсний бахархал, өв соёл

#### **ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- 2.1 Санхүү, төсвийн зохицуулалт
- 2.2 Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр
- 2.3 Аялал жуулчлал
- 2.4 Эрчим хүч

#### **ГУРАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

- 3.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ
- 3.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба
- 3.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм

#### **ДӨРӨВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 4.1 Ногоон хөгжил

#### **ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 5.1 Орон нутаг, хөдөөгийн хөгжил

### **ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

#### **НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Зорилго: Хүний хөгжлийг дэмжих иргэдийг ажилтай орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн, хүний хөгжлийн үзүүлэлт 2019 онд 26 хувь байсныг 2024 онд 30 хувьд хүргэнэ.**

## **1.1. ЭРҮҮЛ МЭНД**

**Зорилт: 1.1.1. Эрүүл мэндийн төвийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрмжийн хангалт 68 хувь байсныг 75 хувьд хүргэнэ.**

### **Арга хэмжээ:**

1.1.1.1. эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх /4D Эхо аппараттай болох./

1.1.1.2. Амбулаторын барилгад их засвар хийх.

1.1.1.3. Багийн эмч нарыг унаажуулах.

1.1.3.4. Эрүүл мэндийн төвийн усны эх үүсвэрт цэвэрлэх төхөөрөмж суурилуулах.

**Зорилт: 1.1.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж, эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

### **Арга хэмжээ**

1.1.2.1. Гэрийн эргэлтийн үйлчилгээний чанарыг сайжруулан, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлгүй ажиллах.

1.1.2.2. Сум дундын эмнэлгийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх.

**Зорилт: 1.1.3. Хүн амын эрүүл мэндийн халдварт бус өвчлөлийн түвшинг 2019 онд 68% байсныг 2024 онд 80%-д хүргэнэ.**

### **Арга хэмжээ:**

1.1.3.1. Иргэдийг халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, арга зүйгээр хангах.

1.1.3.2. Иргэдийг жил бүр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, оношлогоонд хамруулах.

1.1.3.3. Явуулын амбулаторын үзлэгийг аймгийн ЭМГ-тай хамтран жил бүр зохион байгуулж малчид иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.

1.1.3.4. Элэгний С вирус халдвартай иргэдийн 80-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг сайжруулах.

## **1.2. БИЕИЙН ТАМИР, СПОРТ**

**Зорилт: 1.2.1. Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 12 байсныг 2024 онд 50-д хүргэнэ.**

### **Арга хэмжээ:**

- 1.2.1.1. Биеийн тамирын иж бүрэн талбайтай болох.
- 1.2.1.2. Спорт залыг ашиглалтанд оруулах.
- 1.2.1.3. Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг сайжруулах.
- 1.2.1.4. Говь-Угтаал марафон гүйлтийг жил бүр зохион байгуулах.
- 1.2.1.5. Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх

### 1.3 БОЛОВСРОЛ

**Зорилт: 1.3.1 Сургуулийн өмнөх боловсролын орчин нөхцөлийг сайжруулж, хамран сургалт 2019 онд 95.0 хувь байсныг 2024 онд 98.0 хувьд хүргэнэ.**

**Арга хэмжээ:**

- 1.3.1.1. Хүүхдийн цэцэрлэгийн гадаа тоглоомын талбайг тохижуулах
- 1.3.1.2. СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.
- 1.3.1.3. Багш, ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх

**Зорилт: 1.3.2 Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2020 онд 63,7 хувь байсныг 2024 онд 75 хувьд хүргэнэ**

**Арга хэмжээ:**

1.3.2.1. ЕБС-ийн бага боловсролын хамран сургалт 69,9% байсныг 75 %-д, суурь боловсролын хамран сургалт 2019 онд 61,7 % байсныг 2024 онд 70 түүнээс дээш хувьд хүргэх

- 1.3.2.2. Дотуур байрын барилга шинээр барина.
- 1.3.2.3. Сургууль, дотуур байрны гадаад дотоод орчныг камержуулах
- 1.3.2.4. ЕБС-ийн урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.
- 1.3.2.5. Улс аймаг бүсийн чанартай олимпиад тэмцээн уралдаанд амжилттай оролцсон багш, сурагчдыг дэмжин урамшуулах.
- 1.3.2.6. Калиграф монгол уран бичлэгийн сургалтыг тогтмолжуулж шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах.

**Зорилт: 1.3.3. Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт 2019 онд 62.5% байсныг 2024 онд 75%-д хүргэх**

- 1.3.3.1. Багш нарын байрыг бүрэн засварлаж тохижуулах.

1.3.3.2.“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх.

1.3.3.3. Сургуулийн багш нарыг дотоодод туршлага судлуулах.

1.3.3.4. Жил бүр “ ШИЛДЭГ БАГШ” шалгаруулах.

1.3.3.5.Сургуульд байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах

1.3.3.6.Хүүхэд нэг бүрийг “ЗӨВ ХҮН” болгон төлөвшүүлэхэд саначлага гарган ажиллах.

1.3.3.7.Багш нарын орон сууцыг засварлах

1.3.3.8.Хүний хөгжлийн лекц сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулах

## **1.4ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

**Зорилт: 1.4.1.Сумын ажилгүйдлийн түвшин2019 онд 30% байгааг 2024 онд 20% болгож бууруулна.**

**Арга хэмжээ:**

1.4.1.1. Ажилгүй иргэдийг төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамруулж, жил бүр 2 шинэ ажлын байр бий болгох.

1.4.1.2. Идэвхитэй ажил хайж байгаа иргэдээс сул чөлөөтэй байнгын ажлын байранджил бүр 5 иргэнийг зуучлах.

1.4.1.3. Хөдөлмөр эрхлэх төсөлд жил бүр 3 иргэнийг нэмж хамруулан, байнгын ажлын байртай болгох.

**Зорилт: 1.4.2. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн 2иргэнийг байнгын ажлын байранд зуучилна. /жил бүр/**

**Арга хэмжээ:**

1.4.2.1. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалын дагуу / 310 ба түүнээс доош оноотой / сонгогдсон өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулах.

1.4.2.2. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалын дагуу сонгогдсон өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийн жил бүр 5 хувийг нь мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулах.

1.4.2.3. Жил бүр мэргэжил эзэмшүүлэх сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 3хувийг хөтөлбөр төсөлд хамруулах.

**Зорилт:1.4.3.Ахмадуудын нийгэмд оролцох оролцоог 2019 онд 20% байсныг 2024 онд 30 болгон нэмэгдүүлнэ.**

**Арга хэмжээ:**

1.4.3.1. Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд тогтмол хамруулах.

1.4.3.2. Ахмад настнуудыг нас,бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах.

1.4.3.3. Ахмадын спорт, урлагийн бага наадмыг зохион байгуулах.

1.4.3.4. Ахмадад ээлтэй баг, байгууллага шалгаруулж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

1.4.3.5. Уламжлалт зан заншлыг сурталчилан таниулах, өвлөн уламжлах арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

**1.5. Гэр бүл**

**Зорилт: 1.5.1Гэр бүл салалтыг 2019 онд 1,5 хувь байгааг 2024 онд 1,2 хувьд хүргэж бууруулна.**

1.5.1.1. Зорилтот бүлгийн гэр бүлд чиглэсэн сургалт арга хэмжээг зохион байгуулах

1.5.1.2. . Залуучуудад Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн боловсрол олгох сургалт, зөвлөгөөг зохион байгуулах /мэргэжлийн хүнээр/

**Зорилт: 1.5.2 Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилт 2019 онд 80 хувь байсныг 2024 онд 87 хувьд хүргэнэ.**

**Арга хэмжээ:**

1.5.2.1. Зорилтот бүлгийн хүүхдийн судалгааг жил бүр гаргаж, тэднийг дэмжин, өнчин хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх.

1.5.2.2. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд байгууллага,аж ахуйн нэгж, иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх.

1.5.2.3 "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 65-аас доошгүй хувийг чадваржуулах сургалтад хамруулах.

1.5.2.4 Хүүхдэд ээлтэй Говь-Угтаал сум уралдааныг зохион байгуулах.

1.5.2.5.10-17 насны хүүхдүүдэд зориулсан “Миний ертөнц” хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх

1.5.2.6. Хүүхдийн осол гэмтэл, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг нөлөөлөл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

1.5.2.7. “Хөдөлмөр” зуслан байгуулах

**Зорилт: 1.5.3.Залуучуудын нийгмийн хөгжилд оролцох оролцоог 2019 онд 30% байсныг 2024 онд 50%-дхүргэнэ**

**Арга хэмжээ:**

1.5.3.1.Залуучуудад чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлж, хамтран ажиллах.

1.5.3.2. Малчин залуучуудын зөвлөгөөнийг 2 жилд нэг удаа зохион байгуулах

1.5.3.3. Залуучуудын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулах.

1.5.3.4. Төлчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн 2 жилд нэг удаа зохион байгуулах.

1.5.3.5. Мини кино театр байгуулах

## **1.6.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ**

**Зорилт: 1.6.1.Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо 2019 онд 10байсныг 2024 онд 20 хүргэнэ.**

**Арга хэмжээ:**

1.6.1.1.Соёлын биет болон биет бус өв тээгчдийг алдаршуулж, сурталчилна. Өвийг баримтжуулан архивлах.

1.6.1.2. Сумын Музейтэй болох

1.6.1.3.Биет болон биет бус өв тээгч нарыг бий болгох өвлөн уламжлуулах тэмцээн уралдаан, арга хэмжээ зохион байгуулах.

1.6.1.4. Б.Доржпалам агсны 70 насны ойг тэмдэглэх.

1.6.1.5.Боржигон найрны дэг ёсыг архивлах

1.6.1.6. Адуучин тэмцээн зохион байгуулах.

1.6.1.7. “Тэмээний баяр” –ыг зохион байгуулах.

1.6.1.8.Гандан хийдийг тохижуулан эзэнжүүлэх

1.6.1.9. Сумын соёлын төвийн барилгын гадна талыг засварлах

## **ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

### **2.1 Санхүү, төсвийн зохицуулалт**



**Зорилго:**Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуй нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын бааз 2020 онд 7697110.4мянган төгрөг байсныг жил бүр 2 хувиар нэмэгдүүлнэ .

**Зорилт:** 2.1.Төсвийн үр ашгийг дээшлүүлж,санхүүгийн зөрчилгүй ажиллана.

**Арга хэмжээ:**

2.1.1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах

2.1.2. Төсвийн сахилга батыг сайжруулж тэвчиж болох зардлыг танах хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар өр авлагагүй ажиллах.

2.1.3. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь биелүүлэх

**Зорилт:** 2.2.Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтанд орон нутгийн иргэдийн бүлгийн эзлэх хувийг 70 байсныг 80 хувьд хүргэнэ.

**Арга хэмжээ:**

2.2.1.Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймаг, сумын сайт, пейж хуудсаар тухай бүр мэдээлэх

2.2.2. Иргэдийн бүлэгт чадавхжуулах сургалт зохион байгуулах

## **2.2 Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл**

**Зорилт:**2.2.1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо 2019онд 10 байсныг 2024 онд 20-д хүргэнэ.

**Арга хэмжээ:**

2.2.1.1.Мал нядалгааны цэгийг эрүүл ахуйн стандартын дагуу хангуулах.

2.2.1.2. Орон нутгийн онцлогтой “ХӨХҮҮР” брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх.

2.2.1.3 Арьс нэхий, сур суран эдлэлийг уламжлалт аргаар элдэж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх.

2.2.1.4.ЖДҮ-ийн бүтээгдэхүүн борлуулах нэгдсэн дэлгүүр бий болгох

2.2.1.5. Модон эдлэлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх.

2.2.1.6. Хувцас угаалгын үйлчилгээг нэвтрүүлэх.

2.2.1.7. Явган хүний замын хавтанг үйлдвэрлэх.

2.3.1.8. Шил нунтаглах ажлыг хэрэгжүүлэх.

2.3.1.9. Мах, сүүний үйлдвэрлэлийг бий болгох.

2.3.1.10. Тэжээлийн ургамал тариалах иргэдийг дэмжих.

**Зорилт: 2.2.2. Таван төрлийн малын үүлдэрлэг чанар, ашиг шимийг сайжруулна.**

**Арга хэмжээ:**

2.2.2.1. Ашиг, шим сайтай мал бүхий үлгэр жишээ малчны ХОТ бий болгох.

2.2.2.2. Тэмээн сүргийн тоо ашиг шимийг нэмэгдүүлэх

2.2.2.3. Жилд стандартын шаардлага хангасан 1-2 бух бойжуулж, үхэр сүргийн чанарыг үе шаттайгаар сайжруулах.

2.2.2.4. Баяд омгийн ХУЦ, Баяндэлгэрийн Улаан ямааг малчидтай хамтран газар дээр нь очиж судлах ажлыг зохион байгуулах

2.2.2.5. Адуун сүргийн угшлыг сайжруулах

2.2.2.6. вакцины хөргүүртэй болох

**Зорилт: 2.3.3. Сумын бэлчээрийн даац 3 дахин хэтрэлттэй байгаагийн 10га талбайг 2024 он гэхэд нөхөн сэргээнэ.**

**Арга хэмжээ:**

2.3.3.1. Малчдыг өвөлжөө, хаваржааны эзэмшил газрын дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж, хамгаалж талбайн хэмжээг нэмэгдүүлэх

2.3.3.2. Малыг бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худгаар усжуулах.

2.3.3.3. Бэлчээрийн хортонмэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулах.

## **2.3. Аялал жуулчлал**

**Зорилт: 2.4.1. Гадаад, дотоод жуулчдын тоог 2020 онд 0 байсныг 2024 онд 50-д хүргэнэ.**

**Арга хэмжээ:**

2.4.1.1. Их газрын чулууг түшиглэсэн жуулчны бааз байгуулах

2.4.1.2.Орон нутгаа сурталчилсан онцлогийг илтгэсэн бэлэг дурсгалын бүтээгдэхүүн бий болгох.

2.4.1.3. Морьтой монгол аялал “Эвент” арга хэмжээ зохион байгуулах

2.4.1.4.Жуулчдад малчид иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, нөхцөлийг бүрдүүлэх.

## **2.4.Эрчим хүч**

**Зорилт: 2.5.1. Эдийн засгийн хөгжлийг дэмжиж сумын төвийн нийт өрхийг цахилгаан эрчим хүчээр тасалдалгүй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.**

**Арга хэмжээ:**

2.5.1.1.Малчны лагерийг бий болгож дэд бүтэцийн асуудлыг шийдвэрлэх

2.5.1.2.Сумын төвийн гэр хороололын эрчим хүчний шугамд өргөтгөл хийх

## **ГУРАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

### **3.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ**

**Зорилго: Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 45 хувь байсныг 2024 онд 54,хувьд хүргэнэ.**

**Зорилт :3.1.1.Цахимаар үзүүлдэг төрийн үйлчилгээний тоог2019 онд 10% байсныг 40%-д хүргэнэ**

**Арга хэмжээ:** 3.1.1.1. Газрын харилцаа

3.1.1.2. Иргэний бүртгэл

3.1.1.3. Тоон гарын үсэг

3.1.1.4. ERP системийн ашиглалтыг нэмэгдүүлэх

**Зорилт :3.1.2. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан иргэдийн сэтгэл ханамж 2019 онд 25% байсныг 2024 онд 40%-д хүргэнэ.**

3.1.2.1.Сумын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг сар бүр зохион байгуулах.

3.1.2.2. Жилд 1 удаа иргэд олон нийтийн зохион байгуулсан ажил, хандив тусламж, үйл ажиллагааны тайлангаар сонин гаргах

### **3.2. Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба**

**Зорилт:3.2.1. Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 6 хувьтай байсныг 2024 онд 2 хувь болгож бууруулна.**

#### **Арга хэмжээ:**

3.2.1.1. ISO стандартыг нэвтрүүлэх.

3.2.1.2. Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах

3.2.1.3. Төрийн албан хаагчдадтай ёсзүйн гэрээ байгуулж, гэрээг хагас бүтэн жилээр дүгнэх

**Зорилт: 3.3.1 Боловсон хүчний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулж боловсон хүчний бүрдүүлэлт 2020 онд 84 хувь байгааг 2024 онд 90 хувьд хүргэнэ.**

3.3.1.1. Хүний нөөцийн бүртгэл судалгааг жил бүр судлан гаргах

3.3.1.2. Шаардлагатай боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор дэмжих

3.3.1.3. Орон нутгаас суралцаж буй төгсөгчтэй гэрээ хийх

3.3.1.4. Шинээр ирж буй боловсон хүчинд дэмжлэг тусалцаа үзүүлэх

3.3.1.5. Ажиллаж байгаа боловсон хүчнүүдийг чадавхжуулах сургалтанд хамруулах

#### **3.4 Амар тайван, аюулгүй нийгэм**

**Зорилт: 3.4.1. Цагдаагийн ажилчдын ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, гэмт хэргийн гаралтыг бууруулж, шийдвэрлэлт 2019 онд 70%-тай байсныг 80%-д хүргэнэ.**

##### **Арга хэмжээ:**

3.4.1.1. Цагдаагийн кабоныг засварлан тохижуулж, дулаан алдалтыг бууруулах

3.4.1.2. Цагдаагийн ажилтныг унаажуулах

3.4.1.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ төхөөрөмжийг байршуулах.

3.4.1.4. Албан байгууллага, аж ахуйн нэгж, гудамж хорооллыг камержуулалт, гэрэлтүүлэгийн тоог нэмэгдүүлэх.

3.4.1.5. Иргэн, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран архидан согтуурахтай тэмцэх талаар зохион байгуулалттай арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.4.1.6. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах

**Зорилт:3.4.2.Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2019 онд 45 хувьтай байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ.**

**Арга хэмжээ:**

3.4.2.1. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах

3.4.2.2. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг дадлага сургууль, үзлэг зохион байгуулах

3.4.2.3. Гамшигтай тэмцэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

## **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

### **4.1 Ногоон хөгжил**

**Зорилго:Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

**Зорилт: 4.1.1. Шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 2019 онд 35,6 байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ.**

**Арга хэмжээ:**

4.1.1.1. Ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулах

4.1.1.2.Усны сав бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтанд авч тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах

4.1.1.3.Булгийн эхийг хашиж хамгаалах, ойжуулах ажлыг зохион байгуулах

4.1.1.4.Айл өрхийг цэвэр усаар хангах түгээлтийн цамхаг байгуулах

**Зорилт: 4.1.2.Ногоон байгууламжийн хэмжээ 2019 онд 4 га байсныг 2024 онд 9 га-д хүргэнэ.**

**Арга хэмжээ:**

4.1.2.1. Албан байгууллага аж ахуй нэгжийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

4.1.2.2.Сумын хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулах

4.1.2.3. Өрх бүрийг ногоон байгууламжтай болгох

4.1.2.4. Усалгааны системд бүрэн холбох, ногоон байгууламжийн хашааг шинэчлэх

**Зорилт: 4.1.3. Сумын төвийн орчны бохирдлыг бууруулна.**

**Арга хэмжээ:**

4.1.3.1. Сумын төвийн хогийн цэгийг шууж цэгцлэх

4.1.3.2. Хоггүй сум хөтөлбөр хэрэгжүүлэх

4.1.3.3 ангилан ялгах хогийн савтай болох

## **ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

### **5.1 Орон нутаг, хөдөөгийн хөгжил**

**Зорилго:** Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтыг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан нэмэгдүүлж “ ЖИШИГ СУМ” , бүтээн байгуулалтыг өрнүүлнэ.

**Зорилт:5.1.1.“ ЖИШИГ СУМ” бүтээн байгуулалтыг өрнүүлнэ.**

**Арга хэмжээ:**

5.1.1.1.Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болох

5.1.1.2. Гудамжнуудыг жишиг болгох

5.1.1.3. Цэвэрлэх байгууламжийн зураг төсөв хийлгэх

5.1.1.4.Хүүхдийн биеийн тамирын болон тоглоомын талбайг тохижуулах

5.1.1.5.Дулаан цэвэр усны шугамд айл өрхийг холбох

5.1.1.6. Цэвэрлэх байгууламж барих

5.1.1.7.Бохирын зөөврийн машинтай болох.

5.1.1.8.Цахим худгийг нэмэгдүүлэх

5.1.1,8 Гал унтраах объект болон тоног төхөөрөмжтэй болох

5.1.1.9.2022-2032 он хүртэл урт хугацааны стратегий төлөвлөгөөтэй болох

5.1.1.10 Морьт багийн төвтэй болох

**Зорилт:5.1.2.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоо 2019 онд 378 байсныг 2024 онд 850 болгон нэмэгдүүлнэ.**

**Арга хэмжээ:**

5.1.2.1.ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн тоог нэмэгдүүлэх

5.1.2.2.Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг” tusuv-oron nutag.mn” сайтад тухай бүр мэдээлэх

5.1.2.3. ОНХС-ийн чиглэлээр БЗД нарыг чадавхжуулах

ГОВЬ УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР